

СОЦИОЛОГИЧИЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

М.Батбаатар
Социологийн ухааны доктор(Ph.D)

Мэргэжлийн ёс зүй нь судлаач танаар эхэлж, танаар дуусгавар болно.
Социологич Лауренс Ньюман (Social Research Methods)

Шинжлэх ухаан хөгжлийн тодорхой шатанд ирмэгц хөгжлийн зүй тогтол, өөрийн ололт амжилтыг эргэн харахын зэрэгцээ улам бүр институтчлэгдэхийн тулд найдвартай буюу үнэн магадтай, объектив хийгээд бодит байдалд үндэслэсэн [1], илэрхий зөрчил агуулаагүй, үүгээрээ цаг хугацааны шалгуурыг дааж чадахуйц мэдлэгийг бий болгоход анхаарч иржээ. Ялангуяа социологийн шинжлэх ухаан хөгжлийн энэхүү нийтлэг зүй тогтлыг тойроогүй агаад өөрийн дотоод болон гадаад институтчилэгдэх үйл явцад анхаарч ирснийг эл чиглэлийн эрдэмтэд анзааран "социологи дахь социологи" гэж нэрлэсэн нь бий. [2]

Социологийн шинжлэх ухааны хувьд мэдлэг нь тодорхой судлаач, мэргэжил бүхий хувь хүн, байгууллагын туршлага, ур чадвараас хамаарч, олон нийтийн санал бодлын оролцоотойгоор бүтээгддэг тул мэдлэгийн үндэслэлтэй ба үнэн магадтай байдлыг хангахад мэргэжлийн бүлгийн дагаж мөрдөх ёс зүйн дүрэм журам ихээхэн чухал юм. Иймээс ч социологийн шинжлэх ухаан өндөр хөгжсөн улс орнуудын дагаж мөрддөг ёс зүйн дүрэм журамтай танилцан, ёс зүйн зарим стандартуудыг өөрийн орны соёл, онцлогт тохируулан хэрэглэх нь социологи шинэ тутам хөгжиж байгаа орнуудад ихээхэн чухал байна.

Одоогоос 20 орчим жилийн тэртээд АНУ-ын социологичид хамтран социологийн холбоо байгуулж, судалгаа шинжилгээ болон түүнд шаардагдах ёс зүйг бий болгосноор тэд эргэлзээ, маргаантай олон асуудлуудад хариулт өгч чаджээ. Мөн социологийн холбооны дэргэд ёс зүйн хороо байгуулж, ёс зүйн зөрчилтэй тэмцэх болсноор энэ асуудал багассан ба социологийн шинжлэх ухааны нэр хүнд өсөхөд нөлөөлсөн баримт бий. Социологичийн мэргэжлийн ёс зүйн талаар гаргасан дүрэм нь 1989 онд Америкийн социологийн холбооноос гаргасан ёс зүйн товхимол, 1992 онд Америкийн сэтгүүлчдийн нийгэмлэгээс гаргасан сэтгүүлчдийн ёс зүйн тулгуур зарчмуудаас эх үүсвэртэй. [3]

Америкийн социологийн холбооны ёс зүйн дүрэм, зарчмууд болон ёс зүйн хэм хэмжээнүүд нь социологичдын мэргэжлийн үүрэг хариуцлагыг заан үзүүлэхийн зэрэгцээ удирдан чиглүүлэх үндэс нь болдог. Эдгээр зарчим болон хэм хэмжээнүүд нь мэргэжилтний өдөр тутмын үйл ажиллагаанд ерөнхий удирдамж заавар маягаар ашиглагдах ёстой аж.

Америкийн социологийн холбооны ёс зүйн дүрмийн оршил хэсэгт ерөнхий таван зарчим болон ёс зүйн тодорхой хэм хэмжээг нарийвчлан дурдсан байдаг. [3] Эдгээр ёс зүйн дүрмүүд нь мэргэжилтэн судалгааг ёс горимын дагуу гүйцэтгэх, санал гомдлыг шийдэх, удирдан чиглүүлэх, мэргэжлийн ёс зүйн дүрэм журмуудыг тодорхойлж өгдөг ба товчлон сийрүүлвэл,

Зарчим А. Мэргэжлийн ур чадвар, нэр хүнд Социологич нь өөрийн эрхэлж буй ажлын нэр хүндийг дээд зэргээр хамгаалах ёстой. Мөн одоогийн боловсролын хэрэгцээнд тохирсон мэргэжлийн ур чадварыг эзэмшсэн байна. Тэд шинжлэх ухаан, мэргэжил, техник, удирдлагын нөөц зэрэгт холбогдох шаардлагатай мэргэжлийн ур чадвар идэвхийг агуулсан, энэ талын мэдлэгийг ашиглаж чаддаг байх хэрэгтэй. Мөн мэргэжлийн бусад хүмүүс болох оюутнууд, судалгаанд оролцогчид болон туслах ажилтнуудтайгаа тодорхой асуудлаар зөвлөлддөг байвал зохино.

Зарчим Б. Үйл ажиллагааны нэгдмэл байдал Социологич нь үнэнч шударга, эелдэг хүндэтгэлтэй байж судалгааныхаа үйл явцыг чиглүүлэх, бодлого боловсруулах, мэдээллээр нийтэд үйлчлэх хэрэгтэй. Мөн ямар ч тохиолдолд судалгааны ажлаа аз туршсан байдлаар явуулж болохгүй.

Социологич нь ажил хэргийг удирдах явцдаа ямагт өөртөө итгэлтэй байх ёстой агаад санаатайгаар төөрөлдүүлсэн худал ташаа мэдээллийг ашиглахгүй байх үүрэг хүлээнэ.

Зарчим В. Мэргэжлийн үүрэг хариуцлага Социологич нь өөрийн ажлын үүрэг хариуцлага, мэргэжлийнхээ хэм хэмжээг хүлээн авч өндөр түвшинд чандлан биелүүлэх хэрэгтэй. Социологичдын үйл ажиллагаандаа баримтлах онол, арга зүй, аль эсвэл аргууд нь ялгаатай байдаг бөгөөд тэд бусад социологичидтой нэг адил тодорхой асуудлаар зөвшилцдөг. Хэрэв социологич нь хувьдаа ямар нэг зүйлийг завшсан бол мэргэжилтнүүдтэйгээ зөвлөлдөн дүрмийн дагуу сануулах ба дээрх үйлдлийг өөгшүүлэх буюу хаацайлан хамгаалж болохгүй.

Зарчим Г. Хүмүүсийн эрх, эрх чөлөө, тэгш байдлыг сахин хамгаалах Социологич нь бүх хүмүүсийн тодорхой төлөв байдлыг зөв үнэлэх хэрэгтэй. Социологич нь мэргэжлийн үйл ажиллагааны явцад өөрийн сонирхол, үзэл бодлоосоо ангид байж (нас, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг, сексийн баримжаалал) эрүүл саруул нөхцөл байдал, гэрлэлт ба гэр бүлийн байдал, эцэг эхийн байдал, байр суурь зэргээр ялгаварлан гадуурхах үзэлд тулгуурлахгүй байх ёстой. Тэд суралцаж байгаа, сурч байгаа, үйлчилгээ авч буй нийгмийн бүлгүүдэд үйлчлэхдээ хувь хүний, соёлын, үүргийн ялгаатай байдлаа цаг ямагт мэдрэх хэрэгтэй болдог. Мөн тэдгээрийн бүхий л ажил үүрэг болох санал бодол, үнэлэмж, үнэт зүйл зэрэг нь бусдын эрхийн хүрээнд явагдах ёстойг хүлээн зөвшөөрсөн байх нь чухал.

Зарчим Д. Нийгмийн үүрэг хариуцлага Социологич нь шинжлэх ухаан болон мэргэжлийн үүрэг хариуцлагын хүрээнд нийгмийн нийтлэгүүд хийгээд бүлгийн амьдрал, үйл ажиллагааг мэддэг байх ёстой. Ингэхдээ социологийн шинжлэх ухаанд хэрэгтэй, олон нийтэд үр өгөөжтэй судалгаагаар үйлчилнэ.

Дээрх таван зарчим нь аль ч улс оронд даган мөрдөж болохуйц, бүхэлдээ социологичдын үйл ажиллагаа явуулах удирдамж буюу хүсэл эрмэлзлийн шинжтэй, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах идеал загвар юм.

Түүнчлэн социологич мэргэжилтний зүгээс үйл ажиллагаандаа баримтлах тунхаглалын гэхээсээ илүүтэй, прагматик-аргачлалын шинжтэй ёс зүйн зарим стандартуудыг энд дурдах хэрэгтэй. Тухайлбал,

- Социологич өөрийн практик үйл ажиллагаа, сургалт судалгаандаа хуурамч, буруу эсвэл хэрэгцээгүй болсон мэдээ, мэдээллийг ашиглахаас зайлсхийх шинжлэх ухааны болон мэргэжлийн стандарт эзэмшсэн байх.
- Мэргэжлийн дадлага туршлагын хувьд тэдний боловсролын түвшин, сургуулиар олж авсан дадлага туршлагад тулгуурласан ур чадварын стандарт (шинэ арга зүй, аргачлал ашигладаг, шинжлэх ухааны болоод мэргэжлийн өндөр мэдлэгтэй, өөрийн мэдлэгээ бусдад дамжуулах, өвлүүлэх, заавар зөвлөгөө өгөх чадвартай) агуулсан байх
- Орчин үеийн мэргэжилтэн, социологич мэргэжлийн хүмүүс, мэргэжлийн хүрээ, өөрийн үзэл бодол, практик үйл ажиллагаа, сургалт судалгаа, албан ажил болон хүрээлэн буй орчиндоо шударга байдлыг эрхэмлэн хандаж, хувийн ёс суртахууны стандарт (эрдэм шинжилгээний ажлыг хувийн ашиг сонирхлоор бизнесийн шинжтэй болгох, улс төрийн зорилгоор ашиглахаас зайлсхийх, хэрэв ашигласан бол засан залруулах)-ыг сахих

Мөн социологичид нас, хүйс, эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээл, гэрлэлт, гэр бүл, эцэг эхийн байр суурь, арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, хүйсийн баримжаалал, нийгэмд эзлэх байр суурь, ажил төрөл, эдийн засгийн байдал, албан тушаал зэргээр нь хүмүүсийг ялгаварлан гадуурхах, тэднийг мэргэжлийн ашиг сонирхол, эдийн засаг болон хувийн ашиг сонирхлын үүднээс мөлжих арга хэрэгслээ болгохгүй байх, зарим нэг хувь хүмүүс, түүний дотор оюутнууд, удирдаж буй хүмүүс, албан хаагчид, судалгаанд оролцогчдод дарамт үүсгэх ёсгүй ажээ. [4]

Мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээний хувьд социологичид нь мэдээллийн нууцлал, түүний найдвартай байдлыг хангаж, судалгаанд оролцогчид, оюутан, ажилчид, үйлчлүүлэгчид болон бусдын мэдээллийн нууцлалыг хамгаалах үүрэгтэй ба аливаа ашиг орлогын төлөө ёс зүйгээ зөрчин нууц мэдээллийг тараах ёсгүй. Харин нууц мэдээлэлд нэвтрэх эрхтэй хамтран ажилладаг байгууллага болон судалгааны ба сургалтын багийнханд тухайн мэдээллийг үзүүлэх үүрэг хүлээнэ.[3]

Хэрэв социологич тодорхой ба тодорхой бус нөхцөл байдал, үйл явдалд хандахдаа ёс зүйн дүрмийг зөрчвөл, тэд бусад дадлага туршлагатай социологичдоос ёс зүйн дүрмийн талаар асууж лавлах хэрэгтэй. Мөн америкийн социологичдын холбооны мэргэжлийн ёс зүйн хороо болон бусад удирдах газар, албан байгууллагаас зөвлөгөө авч болох ажээ.

Ёс зүйн тогтоосон хэм хэмжээ нь социологичийн үүрэг хариуцлагыг бичиглэн тоочихын зэрэгцээ, зөрчсөн тохиолдолд гишүүдэд тохирох шийтгэл хүлээлгэнэ. Энэ нь хууль дүрмээс үүдэлтэй бөгөөд судлаач үүнийг дагаж мөрдөх ёстой. Гэсэн хэдий ч аливаа ёс зүйн дүрэм журам нь хууль тогтоомж биш учраас тэдгээрийн агуулгын харьцаа, хэв маягийг тодорхойлох шаардлагатай. Юуны өмнө ёс зүйтэй байдал нь ёс суртахуунлаг агаад хууль зөрчөөгүй үед биелэгдэх бололцоотой байдаг бол, амьдрал дээр ёс зүйгүй байдал нь зөвхөн хууль бус, эсвэл зөвхөн ёс суртахуунлаг бус, түүнчлэн дээрх хоёр нөхцлийг аль алиныг нь агуулсан хэлбэрээр оршин байдаг байна.[4] Өгүүлэн буй зүйлээс мэргэжлийн ёс зүй нь судалгаа эхлэхээс дуусах хүртэл, дууссанаас хойш (мэдээллийн нууцлал гм) ч мөрдвөл зохих судлаачийн байнгын "дагуул" гэж дүгнэн хэлж болно.

Америкийн социологийн холбооноос гаргасан ёс зүйн дүрэм журмыг товчлон авч үзсэнээр өнөөгийн Монголын социологичдийн мэргэжлийн ёс зүйд тулгамдаад буй хэд хэдэн зүйлийг өгүүлж болмоор санагдана.

Нэг. Хэдийгээр Монголд социологийн шинжлэх ухаан хөгжиж, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх болсоноор 10 гаруй жилийн нүүр үзэж байгаа боловч, социологич мэргэжилтний үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлдэг иргэний нийгмийн байгууллага байхгүй байгаа нь судалгааг ганцаарчлан хийдэг бие даасан судлаачид, мэргэжлийн бус хүмүүс судалгааг шинжлэх ухаанч бусаар хийхэд хүргэж байна. Энэ нь нийгэмд ч, шинжлэх ухаанд ч тэр аль алинд нь ихээхэн хортой юм. Монголд судалгаа дагнан хийж санхүүждэг олон байгууллага байдаг атлаа социологийн шинжлэх ухааныг түгээн дэлгэрүүлэхэд тэр бүр хувь нэмэр оруулахгүй, түүнчлэн иргэд, олон нийтэд уг шинжлэх ухааны талаар дутуу дулимаг ойлголт (дан ганц анкетын судалгаа мэтээр) төрүүлж буй нь цаг үеийн шинжтэй, мэргэжлийн ёс зүйг мөрдөн сахиулснаар шийдвэрлэж болох асуудал мөн.

Хоёр. Орчин үеийн нийгмийн судалгааг хийхэд ёс зүйн дүрмийн талаар ярихгүйгээр өнгөрч болохгүй юм. Өнөөдөр социологийн мэргэжилтэн даруй 500-д хүрч, олон нийтийн болон төслийн судалгаа хийдэг бие даасан байгууллага, судалгааны төвүүд 20 гаруй болсон ч социологичдын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, нэгтгэн зангидах байгууллагын (Монголын социологийн холбоо) үйл ажиллагаа тааруу бөгөөд бүрхэг байгаа нь ёс зүйн дүрмийн талаар ийн дурдахад хүргэж байгааг өгүүлэх юун.

Гурав. Америкийн социологичдын холбооны гишүүн байх нь америкийн социологийн холбооны гаргасан мэргэжлийн ёс зүйн дүрэм журмыг чандлан баримтлах ёстой гэдгийг эш үндэс болгон “манай орны социологичдын хэдэн хувь нь социологийн холбооны гишүүн бэ?”, “хэрэв гишүүн бол социологийн холбооноос гаргасан дүрэм журмыг хэр зэрэг мэдэх вэ?” гэсэн асуултыг судлаачдад тавибал хуруу дарам цөөхөн нь “тийм” гэж хариулах нь тодорхой юм. Энэ нөхцөл байдлаас дүгнэж үзэхэд социологийн холбооны үйл ажиллагаа нь социологийн мэргэжилтнүүдийн өөрсдийнх нь хичээл зүтгэл, хамтын ажиллагаанаас шууд шалтгаалах бөгөөд ялангуяа өнөөгийн шинээр бэлтгэгдэж буй мэргэжлийн боловсон хүчнүүдэд илүүтэй хамаарах зүйл ажгуу.

Дөрөв. Хөгжлийн үйл явцад тохирсон мэргэжлийн ёс зүйн дүрэм журмыг холбогдох мэргэжлийн холбооноос баталж, зохион байгуулалттайгаар мөрдүүлэх нь хуулийн хэрэгжилт сул, бүхэлдээ “аном” байдалд байгаа өнөөгийн нийгэмд мэргэжлийн бүлгүүдээр дамжуулан ёс зүйг төлөвшүүлж, нийгмийн эмх журмыг тогтоох сайхан боломжийн сацуу, мэдлэгийн үндэслэлтэй, үнэн магадтай чанарыг хангах төдийгүй, шинжлэх ухааны нэр хүндийг бага ч атугай өргөж чадна гэдэгт үүнийг бичигч найдаж байгаа болно.

1. Interpreting qualitative data. D.Silverman
2. Социологический энциклопедический словарь. Г.В.Осипов
3. <http://www.asa.net.org/members/ecoderev.html>
4. Social research methods. L.Newman